

БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, 01 дүгээр сарын 06-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.


Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийв.

Нийт арга хэмжээний 36 буюу 83.7% нь үр дүнтэй, 7 буюу 16.3% нь тодорхой үр дүнд хүрсэн байна. (Хүснэгт 1, График 1)

Хүснэгт 1

Нийт арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/				Нийт үнэлгээ /хувиар/
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
	100 хувь	70-100 хүртэл хувь	30-70 хүртэл хувь	0-30 хүртэл хувь	
43	36	7	-	-	98.4

График 1



Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан ажлууд хамгийн үр дүнтэй буюу 100 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан ажлууд 97.7 хувь, “Инновацад суурилсан цахим

шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан ажлууд 97.1 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
			100 хувь	70-100 хүртэл хувь	30-70 хүртэл хувь	0-30 хүртэл хувь	
1	2	3	4	5	6	8	9
1	Зорилт 1. Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэг, гуравдугаар зорилт)	3	3	-	-	-	100
2	Зорилт 2. Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр зорилт)	11	11	-	-	-	100
3	Зорилт 3. Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний дөрөв, тав, зургаадугаар зорилт)	22	17	5	-	-	97.7
4	Зорилт 4. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэг, гуравдугаар зорилт)	7	5	2	-	-	97.1
	Нийт	43	36	7	-	-	98.4

Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувьтай үнэлэгдсэн нийт 7 арга хэмжээ байна. Үүнд:

1. Арга хэмжээ (21): Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.

Биелэлт: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” болон “Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус батлан байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем”-д үүсгэсэн мэдүүлэг гаргагч нийт 182 албан тушаалтны 2022 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн шинэчлэн гаргуулж, “ХАСХОМ-ийн 2022 оны тайлан”-г 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/328 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 63 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж хэвшлээ. Үүнд:

- Төрийн бусад байгууллагаас шилжин ажиллах-6
- Нэгж хооронд шилжин ажиллах-22
- Нэгж хооронд сэлгэн ажиллах-1
- Төрийн бусад байгууллагаас сэлгэн ажиллах-1
- Төрийн бусад байгууллагад сэлгэн ажиллуулах-1
- Шинээр томилогдох-18
- Дэвшүүлэн томилох-2
- Албан тушаал бууруулсан-2
- Түр орлон гүйцэтгэгчээр томилох-9
- Жинхэлж томилогдох-1

Мөн их хэмжээний орлого мэдүүлсэн 6 албан хаагчийн мэдээллийг “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем”-д бүртгэсэн.

“Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бүртгэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийн дагуу тайлант хугацаанд 100 албан хаагчийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулж, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем”-д бүртгэлээ.

Үнэлгээ: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 97.1 хувьтай үнэлэгдсэн.

2. Арга хэмжээ (22): Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.

Биелэлт: Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 31-ний өдөр хэлэлцэн баталсан.

Байгууллагын даргын 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар төв орон нутаг дахь нэгжийн нийт 252 албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин, нэмэгдэл, 07 дугаар сарын 05-ны өдрийн А/226 дугаар тушаалаар төрийн

захиргааны 174 албан хаагчдын албан тушаалын цалин, төрийн үйлчилгээний 79 албан хаагчдын албан тушаалын ангилал, цалингийн доод хэмжээг тус тус шинэчлэн баталлаа.

Мөн 02 дугаар сарын 20-ны өдрийн А/50 дугаар тушаалаар ажлын цагийн горимд өөрчлөлт оруулан 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 06 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар зарлигаар байгууллагын удирдлагад тэргүүн түшмэлийн дөтгөөр, Монгол Улсын Ерөнхий сайдын 06 дугаар сарын 15-ны өдрийн 410 дугаар захирамжаар 1 газрын даргад эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг дэв шинээр, 2 газрын даргад дэд зэрэг дэв олгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 05 дугаар сарын 29-ний өдрийн А/186 дугаар тушаалаар 2 албан хаагчид ахлах түшмэлийн, 14 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 48 албан хаагчийн зэрэг дэв ахиулан олгуулахаар шийдвэрлүүлэн 07 дугаар сарын 01-ний өдрөөс зэрэг дэвийн нэмэгдлийг олгож эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар баталсан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 41 дүгээр зүйлийн 41.14, 41.18 дахь хэсэгт Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийг хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан. Хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дагалдан гарах журмын төслийг боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгууллагын даргын А/06 дугаар тушаалаар баталж, тогтоолын төслийг боловсруулан 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/597 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Яамнаас тогтоолын төслийг дагалдах журмын хамт боловсруулж, саналаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 06 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн боловч одоогоор тодорхой шийдвэр гараагүй байна.

Байгууллагын даргын 05 дугаар сарын 05-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар албан хаагчдын орон сууц барих асуудлаар Архивын ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан орон сууцны хэрэгцээ, шаардлагын талаар албан хаагчдаас судалгаа авч, дүнг нэгтгэн 05 дугаар сарын 12-ны өдрийн 01-02/70 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Хамтарсан ажлын хэсэг 2 удаа хуралдсан ба одоогийн байдлаар орон сууц барих, хамтран ажиллах барилгын компани судлах, холбогдох мэдээллийг цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн Хан-Уул дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах орон сууц барих 5000 квадрат метр газрыг байгууллагын нэр дээр шилжүүлж өгөх хүсэлтийг 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/92 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлэн хариу хүлээж байна.

Үнэлгээ: “Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.8 хувьтай дүгнэгдсэн.

3. Арга хэмжээ (23): Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.

Биелэлт: Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар 2023 оны сургалтын төлөвлөгөөг 6 дэд бүлгийн 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Дотоод сургалтын талаар:

Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5, мэргэшүүлэх сургалтад 4, дунд хугацааны давтан сургалтад 4, ахлах түшмэлийн багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, нийт 20 албан хаагчийг суралцуулсан.

Байгууллагаас эрх зүйн шинэтгэлийг таниулан хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчийн чадавхыг дээшлүүлж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан 39 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ, 1 удаагийн “Нэгдсэн сургалт, зөвлөгөөн”-д давхардсан тоогоор 2060 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 153 албан хаагчийг тус тус хамруулжээ.

Түүнчлэн байгууллагын даргын тушаалаар албан хаагчдыг ажлын байранд сургах, чадавхжуулах зорилгоор боомт, орон нутаг дахь нэгжийн давхардсан тоогоор 32 албан хаагчийг Виз, зөвшөөрлийн газарт сэлгэн ажиллуулж, боомт, орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын ачааллыг бууруулах зорилгоор төвийн нэгжээс 5 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан.

Гадаад сургалтын талаар:

Гадаад улсад зохион байгуулагдсан 7 удаагийн сургалтад 57 албан хаагчийг хамруулжээ. Үүнд:

- БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа Цагдаагийн дээд сургуулиас зохион байгуулсан “Монгол Улсын хил хамгаалалтын ажил үйлийн семинар” сэдэвт 14 хоногийн сургалтад 10 албан хаагч;

- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад 15 албан хаагч;

- БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан “Хилээр орох, гарах ба цагаачлалын менежментийн семинар” сэдэвт 14 хоногийн сургалтад 20 албан хаагч;

- Тайванийн Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын газраас зохион байгуулсан “2023 оны цагаачлалын албаны ажилтнуудын жишиг сургалт, семинар”-т 2 албан хаагч;

- Тайванийн Минчуаны их сургуульд хятад хэлний мэдлэг дээшлүүлэх 3 сарын сургалтад 3 албан хаагч;

- Унгар улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан “Гадаад иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газрын ерөнхий үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах” 14 хоногийн сургалтад 3 албан хаагч;

- Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохион байгуулагдсан “Баримт бичгийн хуурмаглалтай тэмцэх, туршлага судлах” сургалтад 4 албан хаагчийг тус тус хамруулсан.

Үнэлгээ: “Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 99.3 хувьтай дүгнэгдсэн.

4. Арга хэмжээ (26): Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх.

Биелэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 30-ны өдөр баталж, төлөвлөгөөний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 26 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор төв, орон нутаг дахь нэгжийн 727 орчим албан хаагчийг хамрууллаа. Мөн объектын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 заалт бүхий 01 дүгээр зөвлөмжийг төв, боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03/287 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан болон дэд зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний саналыг 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02/07, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан болон дэд зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний саналыг 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02/08, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн ажлын тайланг 06 дугаар сарын 27-ны өдрийн 02/1091, Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 19-ний өдрийн 02/1030, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 19-ний өдрийн 02/1031 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Үнэлгээ: “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 90 хувьтай дүгнэгдсэн.

5. Арга хэмжээ (35): Худалдан авах ажиллагааны 2023 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах.

Биелэлт: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/132 дугаар тушаалаар шинэчлэн баталсан 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 7 төрлийн 1,300.0 сая төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороо байгуулан tender.gov.mn цахим системд нээлттэй зарлаж, өдөр тутмын сонин хэвлэлээр урилга хүргүүлэн үнийн саналыг цахимаар авч, 1 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын, 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын, 1 арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар тус тус зохион байгуулж, 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан ба 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч санал ирүүлээгүйн улмаас тендер амжилтгүй болсон.

Гэрээ байгуулсан нийт 6 төсөл, арга хэмжээнээс “Нормын хувцас бэлтгэн нийлүүлэх” гэрээний биелэлт 85 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалан төлөвлөгөө 97.5 хувьтай хэрэгжсэн.

6. Арга хэмжээ (40): Нээлттэй мэдээллийг ил тод байлгах

Биелэлт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 116 мэдээллийг нээлттэй байршууллаа. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэлээр 94;

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын 35 мэдээлэл
- Статистикийн 12 мэдээлэл
- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 10 мэдээлэл
- Үйл ажиллагааны 35 мэдээлэл
- Хяналт шалгалтын 2 төлөвлөгөө

Хүний нөөцийн чиглэлээр 21;

- Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журмын талаар 10 мэдээлэл
- Сонгон шалгаруулалтын 5 мэдээлэл
- Салбар зөвлөлийн 2 мэдээлэл
- Сургалтын 2 төлөвлөгөө
- Ажлын байрны 1 тодорхойлолт (нэгж тус бүрээр нийт 95 ажлын байрны тодорхойлолт)
- Авлигын эсрэг үйл ажиллагааны 1 мэдээлэл

Эзэмшиж буй газрын 1 мэдээллийг тус тус байршууллаа.

Shilen.gov.mn цахим хуудаст байршуулсан байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 94 хувийн үзүүлэлттэй байна.

7. Арга хэмжээ (43): Өмнөд бүс дэх газрын албаны барилгын гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Биелэлт: Өмнөд бүс дэх газрын албаны барилгын ажлыг үргэлжлүүлэхээр барилгын материалыг гаалийн татвараас чөлөөлүүлэх тухай хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/764 дүгээр албан бичгээр хүргүүлж, барилгын материалыг хилээр оруулан барилгын ажлыг 06 дугаар сараас эхлүүлсэн. Барилгын ажлыг үргэлжлүүлэх асуудлаар шаардлагатай арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 95 хувьтай, чанар, стандарт, төсвийн зарцуулалтад захиалагч талаас (БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим) явцын хяналт, аудит хийхээр шийдвэрлээд байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 98.4% буюу 4.92 оноотой дүгнэгдлээ. Энэ нь өмнөх оны үнэлгээ буюу 98.2 хувьтай харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (Тус байгууллагыг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам 94.8 хувиар үнэлсэн)

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах яамны хөрөнгө оруулалтаар баригдаж буй албаны барилгын гүйцэтгэлийг захиалагч талд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах;

Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшингийн уялдааг хангаж тайлагнаагүйгээс шалтгаалан үнэлэхэд хүндрэл үүсэж байна. Иймд байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинг оновчтой тодорхойлж, түүнд нийцүүлэн бүрэн гүйцэд, алдаагүй, товч тодорхой тайлагнах;

Зохион байгуулалтын нэгжүүд ажлын уялдаагаа сайжруулах, хамтарч ажиллах, мэдээллээ харилцан солилцох, эргэх холбоог бий болгож, хэрэгжилтийг шаардлагатай.